



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/НЗ

Амардалай

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.2.1 дэх заалт, аймгийн мал эмнэлгийн газрын лабораторийн 2022 оны 06 дугаар сарын 15-ний өдрийн 22-132 бүтгэлийн дугаар бүхий шинжилгээний дүгнэлт, сумын Онцгой комиссын 2022 оны 06 дугаар сарын 16-ний өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Цахиурт багийн нутаг "Өлгий" -д нутаглаж буй малчны суурьт малын гоц халдварт " Бог малын мялзан" өвчин илэрсэн тул 2022 оны 06 дугаар сарын 16-ний өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан малын гоц халдварт богийн мялзан өвчинтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх ажилд Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг сумын Шуурхай штабын дарга (С.Нарантунгалаг)-т даалгасугай.

3. Хорио цээрийн бус нутгийн малд үзлэг тандалт, шинжилгээ, өвчнөөр хорогдсон малын сэг зэмыг устгах, мал сүргийг ариутгал халдваргүйтгэлд хамруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн нэгжийн эмч (М.Даваацэрэн), (М.Ганьхүү), МЭТ-ийн дарга (Д.Наранцэцэг) нарт үүрэг болгосугай.

4. Малчид иргэд олон нийтэд малын гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, гарын авлага, мэдээ мэдээллийг цахимаар олон нийтэд хүргэх, голомт сэжигтэй бүс нийтийн малчдад малын хариуллага маллагаа, хорио цээрийн дэглэмийн журмыг мөрдөж ажиллах талаар хариуцлагын гэрээ байгуулж ажиллахыг ХААТ-ын мэргэжилтэн (Б.Баттогтох), Багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай

5. Дээрх үйл ажиллагаанд шаардлагатай санхүүгийн зардлыг Гамшгаас урьдчилсан сэргийлэх зардлаас гаргаж шийдвэрлэхийг ЗДТГ-ын нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн)-д зөвшөөрсүгэй

ДАРГА

М.БАЯРСҮХ

4880030953